



Эрдэнэс Силвэр Ресурс ХХК

Салхитын мөнгөний орд: Уурхайн хаалтын жишиг төлөвлөгөө

Оролцогч талуудын ажлын хэсгийн уулзалт №1:
Нөхөн сэргээлтийн зорилго, зорилтууд тодорхойлох

2022 оны 1-р сарын 7-ны өдөр

ТАНИЛЦУУЛГА

1. Ажлын хэсгийн зорилго
2. Тодорхойлолт
3. Нөхөн сэргээлт төлөвлөлтийн зорилго, зорилтууд
4. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөлт хийх үндсэн асуудлууд
5. Зорилго, зорилтууд тодорхойлох үйл явц
6. Дараагийн алхмууд

ХӨТӨЛБӨР



1. Ажлын хэсгийн зорилго

1. Уул уурхайн компани, нутгийн иргэд, төрийн захиргааны бүх шатны байгууллагуудын дэмжлэгтэйгээр хаалт, нөхөн сэргээлтийн зорилго, зорилтуудыг боловсруулах.
2. Нөхөн сэргээлтийн дараах газар ашиглалтыг тодорхойлоход талуудын оролцоог хангах.
3. Эцэслэн тодорхойлсон хаалтын зорилго, зорилтуудыг үндэслэн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах.

Энэ бол хамтын ажиллагааг хангах үйл явц. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөнд тусгах эцсийн зорилго, зорилтын талаар “Эрдэнэс Силвер Ресурс” шийдвэр гаргана.

2. Тодорхойлолт

- **Биологийн нөхөн сэргээлт:** Техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт хөрсний үржил шимийг сэргээх, ургамалжуулах үйл ажиллагаа.
- **Хаалт:** Нөхөн сэргээлтийн ажил бүрэн дууссаны дараах хяналт шинжилгээ үйл ажиллагааны эхлэл цэг.
- **Татан буулгах:** Олборлолт, баяжуулалтын үйл ажиллагааг бүрмөсөн зогсоож, цаашид ашиглахгүй уурхайн байгууламж, тоног төхөөрөмжийг буулгах ажиллагаа.
- **Зорилго:** Тодорхой үр дүн эсвэл алсын хараа руу чиглэсэн үйл ажиллагаа

*“Уурхайн нөхөн сэргээлт ба хаалтын гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх”
хээрийн гарын авлагаас иш татав.*

2. Тодорхойлолт

- **Зорилт:** Нөхөн сэргээлтийн ажлыг чиглүүлэх төлөвлөгөөт үр дүн.
- **Нөхөн сэргээлт (Reclamation):** Уурхай зогссоны дараах үлдсэн талбайг тусгайлан нөхөн сэргээх.
- **Нөхөн сэргээлт (Rehabilitation):** Эвдрэлд өртсөн газрыг нөхөн сэргээлтийн дараах ашиглалтын зорилгод нийцүүлэн тогтвортой гадаргуу бүхий үржил шимтэй, өөрийгөө дэмжихүйц экосистем болгон хувиргах цогц үйл ажиллагаа
- **Стандарт:** Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаанд тавих шаардлагыг тодорхойлсон баримт бичиг.

3. Зорилго тодорхойлох ач холбогдол

Зорилго:

- Уурхайн компанийн нэр хүндийг илэрхийлэх
- Уурхайн дараах эцсийн газар ашиглалтын зориулалтыг тодорхойлох
- Орон нутгийн нийгэм- эдийн засгийн хөгжлийн хөтөлбөрүүдтэй уялдуулах
- Нөхөн сэргээлтийн дараах үр дүнг төлөвлөх
- Оролцогч талууд болон олон нийтийн оролцоо, саналыг тусгах

3. Зорилтууд тодорхойлох ач холбогдол


Ерөнхий зорилгын хүрээнд тодорхойлсон дэд зорилтууд нь нөхөн сэргээлтийн эцсийн үр дүнг сайжруулахад чиглэнэ. Хаалтын менежментийн үндсэн зарчмууд буюу доор дурьдсан хандлага, сайн туршлагын ойлголтуудаас нөхөн сэргээлтийн үр дүн ихээхэн хамааралтай байдаг.

- Аюулгүй байдал
- Физикийн тогтвортой байдал
- Химийн тогтвортой байдал
- Нийгэм— эдийн засгийн шилжилт
- Экологийн үр өгөөж, тогтвортой байдал
- Эрсдэлийн удирдлага

4. Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үндсэн ойлголтууд

Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн үндсэн ойлголтууд

Уурхайн амьдралын мөчлөг



Хууль тогтоомж, дүрэм журам, лицензийн шаардлагууд, заавар аргачлал г.м


Батлагдсан уурхайн хаалт болон нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн ажлын зорилго

Нөхөн сэргээлтийн ажлын зорилтууд

Нөхөн сэргээлтийн үндсэн ойлголтууд


Нөхөн сэргээлтийн төлөвлөлтийг хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэх ёстой




Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн үндсэн ойлголт

Уурхайн хаалтын зорилго, зорилтууд юу болох, тэдгээрийг хаалтын төлөвлөлтийн үйл явцад хэрхэн ашиглах тухай ойлголт.

Уурхайн хаалтын төлөвлөлт ба хяналтын тогтолцоо





Нөхөн сэргээлтийн хяналт-шинжилгээ

Нөхөн сэргээсэн
уурхайн талбай хаалтын
эцсийн зорилгод
нийцэж буй эсэхийг
хэмжих хяналтын хүрээ

Кейс жишээ: Алберта мужийн Умард туйлын ойд нөхөн сэргээлт хийх төлөвлөлт



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЭРДЭНЭС
СИЛВЕР
РЕСУРС



In partnership with
Canada



CPP
ENVIRONMENTAL



GROUP
Creating value with knowledge

Кейс жишээ : Нөхөн сэргээлтийн зорилго

Нийтийн эзэмшил
Умард туйлын ойд
эвдэрсэн талбайг
нөхөн сэргээх

Зорилго	Нөхөн сэргээсэн талбай Умард туйлын ойн экосистемийг тэтгэхүйц, олон янз байдлыг дэмжсэн идээшил нутаг бий болгох	Шатлал			
		Полигон	Талбай	Шалгуур үзүүлэлт	Эх сурвалж

Зорилго		Нөхөн сэргээсэн талбай Умард туйлын ойн экосистемийг тэтгэхүйц, олон янз байдлыг дэмжсэн идээшил нутаг бий болгох		Шатлал			
				Полигон	Талбай	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Эх сурвалж
Зорилт 1		Нөхөн сэргээсэн талбай байгалийн экосистемийг үйлчилгээг дэмжихүйц байх					
Шалгуур	1.1	Гадаргуугийн хэлбэржилт байгалийн унаган төрхтэй ойролцоо экосистемийг дэмжихүйц байх					
	Шалгуур үзүүлэлт	1.1.1	Байгалийн төрх		✓	Майлстоун	АС
		1.1.2	Ойролцоох ландшафттай дөхүү байх		✓	Майлстоун	АС
		1.1.3	Гадаргуугийн тогтворшил		✓	Майлстоун	АС
	1.2	Нөхөн сэргээлтэд ашиглах хөрсний материалыг оновчтой байршуулах					
	Шалгуур үзүүлэлт	1.2.1	Нөхөн сэргээлтийн материал байрлуулалт	✓		Майлстоун	АС
		1.2.2	Хөрсний pH	✓		Майлстоун	-
		1.2.3	Хөрсний давсжилт	✓		Майлстоун	-
		1.2.4	Элэгдэл эвдрэл		✓	Майлстоун	АС
		1.2.5	Микро бичил биетний амьдрах орчинг бүрдүүлэх: унанги мод, дов ба хонхор		✓	Майлстоун	-
	1.3	Туйлын холимог ойн дэд бүсэд элбэг тохиолддог ургамлын бүлгэмдэл үүсгэх					
	Шалгуур үзүүлэлт	1.3.1	Ургамалжуулалт	✓		Майлстоун	-

Кейс судалгаа: Зорилго#1 Шалгуур ба шалгуур үзүүлэлт

Хаалтын зорилгод нийцсэн нөхөн сэргээлтийн зорилтууд

Зорилго	Нөхөн сэргээсэн талбай Умард туйлын ойн экосистемийг тэтгэхүйц, олон янз байдлыг дэмжсэн идээшил нутаг бий болгох		Шатлал			
			Полигон	Талбай	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Эх сурвалж

Зорилт 2	Нөхөн сэргээсэн талбайд унаган экосистемийн үйлчилгээг бий болгох					
----------	---	--	--	--	--	--

Шалгуур	2.1	Нөхөн сэргээсэн талбайд шим тэжээлийн эргэлт бий болсон байх				
	Шалгуур үзүүлэлт	2.1.1	Навчлагын шим тэжээл	✓	Хэв маяг/хандлага	-
	2.2	Нөхөн сэргээсэн талбайд экосистемийн үр өгөөж, нөхөн төлжих чадвар тогтсон байх				
	Шалгуур үзүүлэлт	2.2.1	Онцлог шинж чанарууд	✓	Хэв маяг/хандлага	-
		2.2.2	Хөл газрын ургамлууд		✓ Хэв маяг/хандлага	R
		2.2.3	Унаган бус/аграномын төрөл зүйлүүд		✓ Хэв маяг/хандлага	-
		2.2.4	Органик агууламж (LFH)	✓	Хэв маяг/хандлага	-
	2.3	Байгалийн элэгдэл эвдрэлд тэсвэртэй байдал				
	Шалгуур үзүүлэлт	2.3.1	Ургамлын бүрхэвч нөхөн төлжих байдал		✓	-

Кейс судалгаа: Зорилго#2 Шалгуур үзүүлэлт ба индикаторууд

Хаалтын зорилгод нийцсэн Нөхөн сэргээлтийн II зорилт


Зорилго	Нөхөн сэргээсэн талбай Умард туйлын ойн экосистемийг тэтгэхүйц, олон янз байдлыг дэмжсэн идээшил нутаг бий болгох		Шатлал			
			Полигон	Талбай	Шалгуур үзүүлэлтийн төрөл	Эх сурвалж

Зорилт 3		Эцэслэн батлагдсан газар ашиглалтын зорилгод нийцэхүйц газрын чадамжийг дэмжих					
	3.1	Нөхөн сэргээсэн ой эдийн засгийн үр ашигтай байх					
	Шалгуур үзүүлэлт	3.1.1	Уурхайн талбайн индекс	✓		Хэв маяг/хандлага	-
		3.1.2	Ашиглагдахуйц байдал	✓		Майлстоун	-
Шалгуур	3.2	Нөхөн сэргээсэн талбай ан амьтдын идээшил нутаг болсон байх					
	Шалгуур үзүүлэлт	3.2.1	Зэрлэг ан амьтан эргэн нутагших		✓	Хэв маяг/хандлага	АС
	3.3	Нөхөн сэргээсэн талбай уламжлалт газар ашиглалтыг дэмжихүйц байх					
	Шалгуур үзүүлэлт	3.3.1	Уламжлалт ургамал ашиглалт		✓	Хэв маяг/хандлага	-

Кейс судалгаа: Зорилго#3 Шалгуур үзүүлэлт ба индикаторууд

Хаалтын зорилгод нийцсэн Нөхөн сэргээлтийн III зорилт

Кейс жишээ: Зорилтуудын хэрэгжилтэд хяналт тавих



Шалгуур үзүүлэлт		Хяналт хийх хугацаа					
		Газрын хэлбэршүүлэлт	Шимт хөрсний хучилт	Тариалалт (Жил 0)	Ургамлын бүлгэмдэл үүсгэх (Жил 2)	Жил 5	Жил 10
1.1.1	Унаган төрхөд нийцүүлсэн байдал	✓					
1.1.2	Ойролцоох газрын гадаргуутай дөхүү байдал	✓					
1.1.3	Хэлбэржүүлсэн гадаргуугийн тогтворжилт	✓	✓		✓	✓	✓
1.2.1	Нөхөн сэргээлтийн материал байршуулалт		✓				
1.2.2	Хөрсний pH орчин		✓				
1.2.3	Хөрсний давсжилт		✓				
1.2.4	Элэгдэл, эвдрэл	✓	✓	✓	✓	✓	✓
1.2.5	Микро амьдрах орчин	✓	✓				
1.3.1	Ургамлын бүрхэвч үүсгэлт				✓	✓	
2.1.1	Навчлаг шим тэжээл						✓
2.2.1	Индикатор төрөл зүйлүүд			✓	✓	✓	✓
2.2.2	Хөл газрын ургамлууд				✓	✓	✓
2.2.3	Унаган бус/аграномын төрөл зүйлүүд				✓	✓	✓
2.2.4	Органик агууламж (LFH)					✓	✓
2.3.1	Ургамлын бүрхэвч нөхөн төлжих байдал					✓	✓
3.1.1	Уурхайн талбайн индекс					✓	✓
3.1.2	Ашиглагдахуйц байдал	✓					
3.2.1	Зэрлэг ан амьтан эргэн нутагших				✓	✓	✓
3.3.1	Уламжлалт ургамал ашиглалт			✓	✓	✓	✓

Кейс жишээ: Нөхөн сэргээлтийн хяналт шинжилгээний хөтөлбөр

10 жилийн хугацаатай хяналтын хөтөлбөр

Шалгуур үзүүлэлт	1.2.2 Хөрсний pH		
Зорилт	1.0: Нөхөн сэргээсэн талбай байгалийн экосистемийг үйлчилгээг дэмжихүйц байх	Шалгуур үзүүлэлт	1.2: Нөхөн сэргээлтийн материал зорилтот талбайд оновчтой байрлуулах
Шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт	Хөрсний pH орчин		
Шалгуур үзүүлэлтийн ач холбогдол	pH орчин нь ургамлын шим тэжээл, ургалтад нөлөөлнө		
Хэмжилт	Хучилт хийсэн шимт ба шимэрхэг хөрсний дээжлэлтийн чухал үзүүлэлт. Нөхөн сэргээлтийн буцаан дүүргэлт ба хучилт хийсний дараа хэмжинэ. Хэрэв ургамалжуулалтын үр дүн хангалтгүй бол дахин хэмжилт хийх		
Арга зүй	Умардын ойн нөхөн сэргээлт хийх (хөрсний менежмент) шимт хөрсийг үнэлэх тухай Хүснэгт №2-д заасны дагуу 10 га тутамд хөрсний чанарын хэмжилт хийх. Мөн Хүснэгт №3 ёсоор хучилт хийсний дараах шимт болон шимлэг хөрсний гүнийг хэмжих. SM 22 4500 H+B болн бусад батлагдсан хэмжилтийн аргачлалын дагуу лабораторийн шинжилгээ хийх		
Босго түвшин	Шимт хөрсний pH орчин ≥ 5 and ≤ 9		
Эх сурвалж	Албертагийн нөхөн сэргээлт ба газар тариалангийн хөрсний чанарын үзүүлэлт, 1987 оны нэмэлт өөрчлөлт, Хүснэгт 8, Умардын ойн бүсийн ургамалжуулалтын шимт хөрсийг үнэлэх		

Кейс жишээ: : Индикаторын тайлбар хүснэгт

Нөхөн сэргээлтийн хяналт-шинжилгээнд шалгуур үзүүлэлтийн тайлбар хүснэгт ашиглах жишээ


PLAN

DO

CHECK

ADAPT

OUTCOME



Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтийн төлөвлөлт

Дасан зохицох менежмент

Хууль, журам, дүрэм ба стандартууд

Монгол улс нөхөн сэргээлтийг төлөвлөх,
хяналт шинжилгээ хийх цогц хууль,
дүрэм, журам, стандарт зохицуулалттай.



УУЛ УУРХАЙ
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



ЭРДЭНЭС
СИЛВЕР
РЕСУРС



In partnership with
Canada



GROUP
Creating value with knowledge

Эрх зүйн зохицуулалт

Хуулиуд

- | | |
|--|---|
| 1. Ашигт малтмалын хууль | усны сан бүхий газрын |
| 2. Газрын хэвлийн тухай хууль | хамгаалалтын бүс, ойн сан |
| 3. Газрын тухай хууль | бүхий газарт ашигт малтмал |
| 4. Байгаль орчныг хамгаалах
тухай хууль | хайх, ашиглахыг хориглох
тухай хууль |
| 5. Хөрс хамгаалах, цөлжилтөөс
сэргийлэх тухай хууль | 9. Орчны бүсийн тухай хууль |
| 6. Амьтны тухай хууль | 9. Агаарын тухай хууль |
| 7. Ургамлын тухай | 10. Усны тухай хууль |
| 8. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, | 11. Хог хаягдлын тухай хууль |
| | 12. Химийн хорт болон аюултай
бодисын тухай хууль тогтоомж |

Энэхүү жагсаалтыг зөвлөх жишээ хэлбэрээр оруулсан тул зарим хуулийг орхигдуулсан байж болзошгүй.

Эрх зүйн зохицуулалт

Дүрэм журмууд

1. Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын түр журам
2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай дансны гүйлгээнд хяналт тавих журам
3. Ил уурхайн аюулгүй ажиллагааны нийтлэг шаардлага

Энэхүү жагсаалтыг зөвлөх жишээ хэлбэрээр оруулсан тул зарим дүрэм журмыг орхигдуулсан байж болзошгүй.

Эрх зүйн зохицуулалт


1. MNS 6297: 2011. Ашигт малтмалыг нуруулдан болон овоолон уусгах үйлдвэрийн хаалт. Ерөнхий шаардлага. Хамрах хүрээ.
2. MNS 5914:2008 MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
3. MNS 5915:2008 MNS 5915 : 2008. Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллгаагаар эвдэрсэн газрын ангилал. Хамрах хүрээ.
4. MNS 5916:2008 Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
5. MNS 5917:2008 Байгаль орчин. Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага.
6. MNS 5918:2008 Байгаль орчин: Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
7. MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. Хамрах хүрээ.
8. MNS 2305: 1994 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам. Хамрах хүрээ.
9. MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. Хамрах хүрээ.

Энэхүү жагсаалтыг зөвлөх жишээ хэлбэрээр оруулсан тул зарим стандартыг орхигдуулсан байж болзошгүй.

Стандартууд

5. Зорилго, зорилтууд тодорхойлох үйл явц





Зорилго тодорхойлох

Хаалтын төлөвлөлтийн зорилго, зорилтууд болосруулахад дотоод болон гадаад хүчин зүйлсийг харгалзан үзэх

Зорилго тодорхойлох

Хаалтын зорилго тодорхойлоход хаалтын менежментийн үндсэн зарчмуудыг мөрдлөг болгох.

Дэд зорилтууд нэг ба түүнээс дээш зарчимтай нийцэх боломжтой.

- **Аюулгүй байдал:** Уурхайн талбайг хүн ба амьтанд аюулгүй болгох.
- **Физик тогтворшил:** Газар хөндөлтийн улмаас хүн ба амьтанд эрсдэлгүй, тогтвортой орчинг бий болгох.
- **Химийн тогтворшил:** Уурхайн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд химийн бохирдол үүсэх эрсдэлээс сэргийлэх
- **Нийгэм –эдийн засгийн шилжилт:** Уурхай хаасны дараах нийгэм- эдийн засгийн ямар нэгэн сөрөг нөлөөллийг бууруулах практик арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх.
- **Экологийн үр өгөөж:** Хаалтын дараах газар ашиглалтын зорилгод нийцэхүйц, тогтвортой, эко тогтолцоо бий болгох
- **Эрсдэл бууруулах:** Эрсдэлийг зөвшөөрөгдөх төвшин хүртэл бууруулах.

Нөхөн сэргээлтийн зорилгуудыг үнэлэх

#	Үнэлгээний шалгуур: ЗОРИЛГУУД	Оноо				
1	Уурхайн хаалтын төсөөлөл буюу урьдчилсан төлөвлөгөөг урт хугацаанд, уурхайн онцлогт тохируулан боловсруулсан эсэх?	1	2	3	4	5
2	Хаалтын урьдчилсан төлөвлөгөөнд байгаль орчин, нутгийн иргэд, ажиллах хүчин ба санхүүгийн нөөц зэрэг хүчин зүйлүүдийг авч үзсэн эсэх?	1	2	3	4	5
3	Хаалтын урьдчилсан төлөвлөгөөнд холбогдох эрх зүйн шаардлагууд, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг харгалзсан эсэх?	1	2	3	4	5
4	Хаалтын урьдчилсан төлөвлөгөөнд уурхайн дараах газар ашиглалтын хэлбэрийг тодорхойлсон эсэх?	1	2	3	4	5
5	Хаалтын урьдчилсан төлөвлөгөөг боловсруулахад дотоод болон гадаад оролцогч талуудтай зөвлөлдсөн эсэх?	1	2	3	4	5
6	Хаалтын урьдчилсан төлөвлөгөө компанийн бизнес төлөвлөлт, төрийн захиргааны болон нутгийн захиргаа, нөлөөлөлд өртсөн иргэдийн хүлээлт, ашиг сонирхол, ирээдүйн газрын эзэмшигчийн чадавхтай нийцэж буй эсэх?	1	2	3	4	5
7	Энэхүү хаалтын урьдчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтой эсэх?	1	2	3	4	5

Хаалт, нөхөн сэргээлтийн зорилтуудыг үнэлэх

#	Үнэлгээний шалгуур үзүүлэлт: ЗОРИЛТУУД	Оноо				
1	Зорилтууд хэмжигдэхүйц эсэх?	1	2	3	4	5
2	Нөхөн сэргээлтийн өнөөгийн технологи, практик туршлагаар хэрэгжихүйц эсэх?	1	2	3	4	5
3	Зорилтууд өртөг, зардлын хувьд үр ашигтай эсэх?	1	2	3	4	5
4	Зорилтууд биелэгдэхүйц эсэх?	1	2	3	4	5
5	Зорилтууд эцсийн зорилго ба хаалтын үндсэн зарчмуудад нийцэж буй эсэх?	1	2	3	4	5
6	Хаалт, нөхөн сэргээлтийн зорилтуудыг дотоод болон гадаад оролцогч талуудтай зөвлөлдөх зарчмаар боловсруулсан эсэх?	1	2	3	4	5

6. Дараагийн алхмууд



№	Уулзалтын гол сэдэв, зорилго
1	Хаалтын төлөвлөлтийг чиглүүлэх ёстой нөхөн сэргээлтийн зорилго, зорилтууд боловсруулах ач холбогдлыг таниулах. Ажлын хэсгийн гишүүд нөхөн сэргээлтийн зорилго, зорилтуудыг оновчтой тодорхойлох ач холбогдлыг ойлгуулах.
2	Зорилго тодорхойлох. Олон улсын болон дотоодын туршлага, сайн жишээнүүдийг танилцуулах. Санал авах хэлэлцүүлэг хийж, оролцогчдод мэдлэг, ойлголт өгөх. Ихэвчлэн уурхайн ул мөр хамарч буй талбайн хэмжээнээс шалтгаалан нөхөн сэргээлтийн зорилгыг тодорхойлдог туршлагатай. Гэвч, уурхайн эдэлбэр газар бага тохиолдолд уурхайн онцлогт тохирсон шийдэл гаргах боломжтой. (Тухайлбал, уурхайн талбайг бусад үйлдвэрлэлийн зорилгоор ашиглах боломжтой).
3	Боломжит хувилбаруудыг нарийвчлан хэлэлцэх, шийдвэр гаргах процессыг чиглүүлэх. Ихэвчлэн нөхөн сэргээлтийн 2-3 дэд зорилтыг боловсруулдаг. Хэт олон зорилго зөрчил үүсгэх магадлалтай Сонгосон хувилбаруудын давуу ба сул талыг зөвшилцөх.
4	Хэлэлцүүлэг хийж талуудын олонхын дэмжлэг хүлээсэн зорилго, зорилтуудыг санал болгох. Эрдэнэс Силвер Ресурс ХХК тодорхойлсон зорилгуудыг хянаж, санал өгөх
5	Зорилтууд танилцуулах. Компанийн саналыг авсны дараа, CPP энвойранментал зорилго тус бүрийн хүрээнд дэд зорилтууд боловсруулж оролцогч талуудад танилцуулна. Хаалтын төлөвлөлтийг чиглүүлэхэд эдгээрийн ач холбогдлыг таниулна.
6	Зорилтуудыг хэлэлцүүлж, эцэслэх. Зорилго зорилтуудыг хэлэлцүүлж, оролцогч талуудын санал, зөвлөмжийг авах.
7	Эцэслэн тодорхойлсон зорилтуудыг оролцогч талуудад танилцуулах. Шаардлагатай бол өөрчлөлт, засвар хийх. Эрдэнэс Силвер Ресурс ХХК эцсийн байдлаар баталгаажуулна

6. Дараагийн алхмууд

Ажлын хэсгийн уулзалт:

Хаалт, нөхөн сэргээлтийн зорилгуудыг тодорхойлох ажлын хэсгийн 7 удаагийн уулзалт хийхээр төлөвлөсөн.

Эрдэнэс Силвер Ресурс ХХК тодорхойлсон зорилго, зорилтуудыг эцсийн байдлаар баталгаажуулна

1. 2022 оны 1 сарын 7
2. 2022 оны 1 сарын 12
3. 2022 оны 1 сарын 13
4. 2022 оны 2 сарын 16
5. 2022 оны 2 сарын 17
6. 2022 оны 2 сарын 23
7. 2022 оны 2 сарын 24

2022 оны I сар

S	M	T	W	T	F	S
						1
2	3	4	5	6	7	8
9	10	11	12	13	14	15
16	17	18	19	20	21	22
23	24	25	26	27	28	29
30	31					

2022 оны II сар

S	M	T	W	T	F	S
		1	2	3	4	5
6	7	8	9	10	11	12
13	14	15	16	17	18	19
20	21	22	23	24	25	26
27	28					

Хуваарь

Зорилго тодорхойлох
Ажлын хэсгийн уулзалтын
хуваарь

Хагас өдрийн уулзалтууд.
3 уулзалтыг өдөр дараалж
хийнэ.

Баярлалаа!
Асуулт?